



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгонтэнгэр рашаан сувилалын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/078/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул
Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	<u>4</u>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<u>5</u>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	<u>6</u>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	<u>7</u>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ОТГОНТЭНГЭР РАШААН
СУВИЛЛЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЦОЛМОН-Д

2025.02.18 № 145
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Отгонтэнгэрийн Рашаан сувиллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгонтэнгэрийн Рашаан сувиллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогоор 208.7 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 34.3 сая төгрөгийг бүрдүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Отгонтэнгэрийн Рашаан сувиллын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Отгонтэнгэрийн Рашаан сувилалын газарт 2024 онд 870 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

812509930

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****2023 оны 12 дугаар сарын 31****/төгрөгөөр/**

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ ДҮН	44,103,289.04	100,539,176.99
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ		876.99
3	Банкинд байгаа бэлэн байгаа		876.99
4	Төгрөг		876.99
5	Төрийн сангийн харилцах		876.99
6	АВЛАГА	10,256.04	67,962,700.00
7	Татаас, санхүүжилтийн авлага		67,962,700.00
8	Бусад авлага	10,256.04	
9	Хувь хүмүүсээс авах авлага	10,256.04	
10	БАРАА МАТЕРИАЛ	44,093,033.00	32,575,600.00
11	Түүхий эд материал	17,729,735.00	13,495,600.00
12	Тусгай зориулалтай материал	16,475,300.00	12,045,600.00
13	Эм боох материал	1,254,435.00	1,450,000.00
14	Хангамжийн материал	26,363,298.00	19,080,000.00
15	Бичиг хэргийн материал	320,500.00	250,000.00
16	Аж ахуйн материал	18,450,000.00	10,450,000.00
17	Түлш, шатах тослох материал	5,400,000.00	6,100,000.00
18	Хүсний материал	1,538,000.00	1,050,000.00
19	Бусад материал	654,798.00	1,230,000.00
20	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	90,615,158.75	77,151,699.03
21	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	90,615,158.75	77,151,699.03
22	Биет хөрөнгө	21,173,158.75	7,709,699.03
23	Барилга, байгууламж, орон сууц	112,599,600.00	112,599,600.00
24	Хуримтлагдсан элэгдэл	(112,266,267.72)	(112,377,378.48)
25	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,041,639.48	39,041,639.48
26	Хуримтлагдсан элэгдэл	(29,044,732.05)	(32,916,750.20)
27	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,891,379.96	50,891,379.96
28	Хуримтлагдсан элэгдэл	(40,207,580.42)	(49,687,911.23)
29	Бусад үндсэн хөрөнгө	9,816,000.00	9,816,000.00
30	Хуримтлагдсан элэгдэл	(9,816,000.00)	(9,816,000.00)
31	Ном	159,119.50	159,119.50
32	Биет бус хөрөнгө	69,442,000.00	69,442,000.00
33	Бусад биет бус хөрөнгө	69,442,000.00	69,442,000.00
34	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	134,718,447.79	177,690,876.02
35	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,622,769.82	60,036,457.78
36	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,622,769.82	60,036,457.78
37	Өглөг	24,622,769.82	60,036,457.78
38	Ажилчидтай холбогдсон өглөг	24,622,769.82	19,453,800.00
39	Бусад өглөг		40,582,657.78
40	Байгууллагад төлөх өглөг		28,456,300.00

41	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		12,126,357.78
42	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	110,095,677.97	117,655,295.23
43	Засгийн газрын хувь оролцоо	110,095,677.97	117,655,295.23
44	Засгийн газрын оруулсан капитал	211,301,260.12	211,301,260.12
45	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	211,301,260.12	211,301,260.12
46	Хуримтлагдсан үр дүн	(102,240,553.26)	(94,680,936.00)
47	Өмнөх үеийн үр дүн	(92,514,918.37)	(102,240,553.26)
48	Тайлант үеийн үр дүн	(9,725,634.89)	7,558,740.27
49	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,034,971.11	1,034,971.11
50	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	134,718,447.79	177,690,876.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН(I)	305,185,800.00	310,304,400.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,573,000.00	33,550,000.00
3	Нийтлэг татварын бус орлого	2,573,000.00	33,550,000.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,573,000.00	33,550,000.00
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,573,000.00	33,550,000.00
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,612,800.00	276,754,400.00
7	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	302,612,800.00	276,754,400.00
8	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	302,612,800.00	276,754,400.00
9	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	314,911,434.89	302,745,659.73
10	УРСГАЛ ЗАРДАЛ	314,911,434.89	302,745,659.73
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,911,434.89	302,745,659.73
12	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,832,558.14	58,347,462.01
13	Үндсэн цалин	32,063,423.29	41,200,820.75
14	Нэмэгдэл	18,769,134.85	17,146,641.26
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,300,000.00	20,126,357.75
16	Тэтгэврийн даатгал	16,300,000.00	20,126,357.75
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,524,916.39	11,850,000.00
18	Гэрэл цахилгаан	645,606.39	
19	Түлш халаалт	7,500,000.00	11,850,000.00
20	Цэвэр, бохир ус	3,379,310.00	
21	Байрны түрээс	4,000,000.00	
22	Хангамж, бараа материалын зардал	24,801,158.03	14,489,616.00
23	Бичиг хэрэг	1,154,850.00	522,050.00
24	Тээвэр, шатахуун	13,918,900.00	1,878,466.00
25	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,128,700.00	
26	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	175,000.00
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	7,538,708.03	11,914,100.00
28	Норматив зардал	90,337,847.50	112,259,195.01
29	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,886,764.50	36,436,985.00
30	Хоол хүнс	58,131,083.00	70,764,210.01
31	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,320,000.00	5,058,000.00

32	Эд хогшил, урсгал засварын зардал	27,371,227.47	797,000.00
33	Багаж, техник хэрэгсэл	6,185,000.00	797,000.00
34	Урсгал засвар	21,186,227.47	
35	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр, хураамж	77,250,839.86	71,412,569.24
36	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	75,750,839.86	69,206,542.25
37	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	1,600,000.00
38	Газрын төлбөр	800,000.00	605,150.00
39	Бараа үйлчилгээний бусад зардал	12,492,887.50	13,463,459.72
40	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,492,887.50	13,463,459.72
41	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-9,725,634.89	7,558,740.27
42	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VI)-(V)	-9,725,634.89	7,558,740.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны мөнгөн дүн (I)	302,111,300.00	242,341,700.00
2	Татварын бус орлого	2,573,000.00	33,550,000.00
3	Нийтлэг татварын бус орлого	2,573,000.00	33,550,000.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,573,000.00	33,550,000.00
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,573,000.00	33,550,000.00
6	ТУСЛАМЖ,САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,538,300.00	208,791,700.00
7	Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	299,538,300.00	208,791,700.00
8	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	299,538,300.00	208,791,700.00
9	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	302,111,300.01	242,340,823.01
10	УРСГАЛ ЗАРДАЛ	302,111,300.01	242,340,823.01
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛЭЭНИЙ ЗАРДАЛ	302,111,300.01	242,340,823.01
12	Цалин хөлс нэмэгдэл урамшил	50,832,558.15	38,803,662.01
13	Үндсэн цалин	32,063,423.29	31,657,020.75
14	Нэмэгдэл	18,769,134.86	7,146,641.26
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,300,000.00	8,000,000.00
16	Тэтгэврийн даатгал	16,300,000.00	8,000,000.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,524,916.39	
18	Гэрэл,цахилгаан	645,806.39	
19	Түлш,халаалт	7,500,000.00	
20	Цэвэр,бохир ус	3,379,310.00	
21	Байрны түрээс	4,000,000.00	
22	Хангамж,бараа материалын зардал	18,847,250.00	16,869,116.00
23	Бичиг хэрэг	1,135,950.00	451,550.00
24	Тээвэр, шатахуун	13,918,700.00	12,328,466.00
25	Шуудан, холбоо,интернэтийн төлбөр	2,128,700.00	
26	Хог хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	175,000.00
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх,хуйн эд зүйлс	1,603,700.00	3,914,100.00

28	Нормативт зардал	90,491,248.00	119,483,695.00
29	Эм,бэлдмэл,эмнэлгийн хэрэгсэл	28,162,100.00	36,632,550.00
30	Хоол хүнс	58,009,148.00	75,793,145.00
31	Нормын хувцас,зөөлөн эдлэл	4,320,000.00	7,058,000.00
32	Эд хогшил,урсгал засварын зардал	27,371,227.47	24,065,200.00
33	Багаж,техник,хэрэгсэл	6,185,000.00	797,000.00
34	Урсгал засвар	21,186,227.47	23,268,200.00
35	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр,хураамж	82,744,100.00	35,119,150.00
36	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,244,100.00	32,914,000.00
37	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	1,600,000.00
38	Газрын төлбөр	800,000.00	605,150.00
39	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	-0.01	876.99
40	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(VIII)=(III)+(VI)+(VII)	-0.01	876.99
41	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.01	
42	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		876.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,301,260.12	1,034,971.11	(92,514,918.37)	119,821,312.86
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,301,260.12	1,034,971.11	(92,514,918.37)	119,821,312.86
3	Тайлант үеийн үр дүн			(9,725,634.89)	(9,725,634.89)
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,301,260.12	1,034,971.11	(102,240,553.26)	110,095,677.97
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,301,260.12	1,034,971.11	(102,240,553.26)	110,095,677.97
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,301,260.12	1,034,971.11	(102,240,553.26)	110,095,677.97
7	Тайлант үеийн үр дүн			(7,558,740.27)	7,558,740.27
8	2024 оны 6-р сарын 30-нээрх үлдэгдэл	211,301,260.12	1,034,971.11	(94,681,812.99)	117,654,418.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	657,695,000.00	242,340,823.01
3	НИЙТ ЗАРЛАГА	657,695,000.00	242,340,823.01
4	УРСГАЛ ЗАРДАЛ	657,695,000.00	242,340,823.01
5	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,695,000.00	242,340,823.01

6	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,180,500.00	38,803,662.01
7	Үндсэн цалин	182,496,000.00	31,657,020.75
8	Нэмэгдэл	82,123,200.00	7,146,641.26
9	Унаа хоолны хөнгөлөлт	8,712,000.00	-
11	Урамшуулал	32,849,300.00	-
12	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	38,272,500.00	8,000,000.00
13	Тэтгэврийн даатгал	26,025,300.00	8,000,000.00
14	Тэтгэмжийн даатгал	3,061,800.00	-
15	ҮОМШӨ-ний даатгал	1,530,900.00	-
16	Ажилгүйдлийн даатгал	1,530,900.00	-
17	Эрүүл мэндийн даатгал	6,123,600.00	-
20	Хангамж, бараа материалын зардал	26,989,800.00	16,869,116.00
22	Бичиг хэрэг	2,040,000.00	451,550.00
23	Тээвэр, шатахуун	15,423,300.00	12,328,466.00
24	Шуудан холбоо, интернетийн төлбөр	4,136,000.00	-
25	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн урсгал, ариутгал	883,000.00	175,000.00
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	4,507,500.00	3,914,100.00
28	Нормативт зардал	215,789,400.00	119,483,695.00
30	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	121,875,000.00	36,632,550.00
31	Хоол хүнс	86,806,200.00	75,793,145.00
32	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,108,200.00	7,058,000.00
33	Эд хогшил, урсгал засварын зардал	26,562,500.00	24,065,200.00
34	Багаж, техник хэрэгсэл	6,500,000.00	797,000.00
35	Урсгал засвар	20,062,500.00	23,268,200.00
37	Томилолт, зочны зардал	558,000.00	-
38	Дотоод албан томилолт	558,000.00	-
39	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	43,342,300.00	35,119,150.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,500,300.00	32,914,000.00
43	Даатгалын үйлчилгээ	73,500.00	-
44	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	-
45	Тээврийн хэрэгслийн оношилгоо	16,800.00	-
46	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,000,000.00	1,600,000.00
47	Газрын төлбөр	2,524,000.00	605,150.00
48	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	-
49	Мөнгөн хөрөнгийн эхнийн үлдэгдэл		
50	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		876.99

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Отгонтэнгэр рашаан сувилалын зорилго: Уламжлалт анагаах ухааны мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх, чадварлаг боловсон хүчин бүхий эмнэлэг болон хөгжих

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 79 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Отгонтэнгэр рашаан сувилалын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд сувилалын дарга хяналтыг хэрэгжүүлж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгонтэнгэр рашаан сувилалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Отгонтэнгэр рашаан сувилалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 42,972.0 мянган төгрөгөөр буюу 32 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Төрийн сангийн харилцах		0.87	0.87
Авлага	10.2	67,962.7	67,952.5
Бараа материал	44,093.0	32,575.6	-11,517.4
Үндсэн хөрөнгө	90,615.2	77,151.7	-13,463.5
Нийт хөрөнгө	134,718.4	177,690.8	42,973.4
Өглөг	24,622.7	60,036.4	35,413.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	110,095.7	117,654.4	7,558.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	134,718.4	177,690.8	42,972.4

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Мөнгөн хөрөнгийн дансны хувьд оны эцсийн үлдэгдэл 0.87 мянган төгрөг байна.

Авлагын эхний үлдэгдэл 10.2 мянган төгрөг байсныг барагдуулсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 67,962.7 мянган төгрөгийн авлага шинээр нэмэгдсэн байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 44,093.0 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 136,177.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 147,695.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 32,575.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,517.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд өөрчлөлт ороогүй, элэгдэл тооцогдсоноор хөрөнгийн үлдэгдэл 13,463,5 мянган төгрөгөөр буурсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 35,413.7 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээ бүрэн аваагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 42,972.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 352,835.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар, өөрийн орлогоор 304,859.4 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 208,791.7 мянган төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авч, өөрийн орлогоор 33,550.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт нь 67,962.7 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 242,340.8 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
71601	Нийгмийн эрүүл мэнд				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	657,695.0	242,341.7	415,353.3	36.8%
НИЙТ		657,695.0	242,340.8	415,353.3	36.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

<i>/мянган төгрөг/</i>				
№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан	13,642.0	13,642.0
2	Шууд гэрээ байгуулах	Галын түлээ худалдан авсан	13,000.0	13,000.0
3	Шууд гэрээ байгуулах	Хоол хүнсний материал худалдан авсан	15,000.0	15,000.0
4	Шууд гэрээ байгуулах	Шатахуун худалдан авсан	1,878.5	1,878.5
5	Шууд гэрээ байгуулах	И клиник програмын гэрээ байгуулсан	1,600.0	1,600.0
6	Шууд гэрээ байгуулах	Урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн	13,990.5	13,990.5
7	Шууд гэрээ байгуулах	Засварын материал худалдан авсан	4,096.2	4,096.2
8	Шууд гэрээ байгуулах	Мах худалдан авсан	8,656.0	8,656.0

ДҮН	71,863.2	71,863.2
------------	-----------------	-----------------

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгонтэнгэр рашаан сувилалын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Отгонтэнгэр рашаан сувилалын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 03 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 302,745.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,521.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Отгонтэнгэр рашаан сувилалын шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Отгонтэнгэр рашаан сувилалын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар тайлант оны төсвийн төлөвлөлтийг бодитой бус төлөвлөсөн, өөрийн орлогын төлөвлөгөө 86.6 хувиар тасарсан зөрчлийг илрүүлэн зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж

1.1. Илрүүлэлт:

- Отгонтэнгэр рашаан сувилал нь 2024 оны төсвийн төлөвлөгөөнд өөрийн орлогыг 304,859.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч 33,550.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнан, 86.6 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын сангаас 352,835.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 266,250.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар тооцоо нийлсэн нь үйлчлүүлэгчийн тоо буурсан, төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслээгүй зэрэгтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж:

- Өөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэйгээр төлөвлөх, хэвтэн эмчлүүлэгсдийн тоог нэмэгдүүлэн, үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

/мянган төгрөгөөр/

Дүн												
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тоо	Тоо	Дүн
Өөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэйгээр зөв төлөвлөх	1	0.00					1	0.00				
Дүн	1	0.00					1	0.00				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АХЛАХ АУДИТОР
 БОЛОВСРУУЛСАН
 СҮЛД АУДИТ ХХК-ИЙН
 ГЭРЭЭТ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА
 Х.БОЛДБААТАР
 Г.ЗАЯА

Ц.АЛТАНТУУЛ

ОГНОО: 2025-02-22